



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

20/6 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 8/28

Улаанбаатар хот

Г Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 10.1, 24.2, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын "Журамд өөрчлөлт оруулах тухай" 2016 оны А/184 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт"-ын "А. Мансууруулах эмийн жагсаалт"-ын 14 дүгээрт заасан "транс - (±) - 2 - [(Диметиламино) метил]- 1 - (3-метоксифенил) циклогексанол" химийн нэршил бүхий Трамадол эмийг уг жагсаалтаас хассугай.

2. Дээрх тушаалын хавсралтын "Б. Сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт"-ын 33-т "Трамадол" /химиин нэршил "транс - (±) - 2 - [(Диметиламино) метил]- 1 - (3-метоксифенил) циклогексанол"/ гэж нэмсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д. Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



А. ЦОГЦЭЦЭГ

080111